



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 01 дүгээр сарын 15  
№03 (1299)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |     |   |     |
|-----|---|-----|
| 39. | Засгийн газрын тусгай сангийн тухай<br>хуульд өөрчлөлт оруулах тухай                      | 179 |
| 40. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай<br>хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 182 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |  |            |     |
|-----|--|------------|-----|
| 41. | Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит<br>сонгууль товлон зарлах, санал авах өдрийг<br>тогтоох тухай | Дугаар 116 | 185 |
| 42. | Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчийн<br>албан тушаалаас чөлөөлөх тухай                            | Дугаар 119 | 187 |
| 43. | Монгол Улсын Ерөнхий аудиторовын<br>үүрэгт ажлаас чөлөөлөх тухай                                     | Дугаар 120 | 188 |
| 44. | Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн<br>дарга, гишүүний цалингийн хэмжээг<br>тогтоох тухай           | Дугаар 121 | 189 |
| 45. | Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр<br>томилох, гишүүнээс чөлөөлөх тухай                            | Дугаар 01  | 191 |





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.1.Эрүүл мэндийг дэмжих сан нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх болон амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгох зориулалттай байна.

19.3.Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

19.3.1.иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа;

19.3.2.хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах үйл ажиллагаа;

19.3.3.эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;

19.3.4.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа;

19.3.5.зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх;

19.3.6.тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж.”

**2 дугаар зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийн “зарцуулах” гэснийг “төвлөрүүлэн зарцуулах” гэж өөрчилсүгэй.



**Идэвхтэй Фолд\_02 Нөдөл**

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

1. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

6. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/17<sup>1</sup> дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг:**

“4.Цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцно.

5.Цэргийн алба хаагч эмэгтэйн энэ хуулийн 17<sup>1</sup> дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэлийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, шилжүүлнэ.”

#### **2/24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдсон зааврыг батлан хамгаалахын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

**2 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Цэргийн албыг 10-аас доошгүй жил хаасан цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч ажлаас чөлөөлөгдвөл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.”

**3 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “халагдсан бол” гэснийг “чөлөөлөгдсөн бол” гэж, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “халагдах тохиолдолд” гэснийг “чөлөөлөгдсөн тохиолдолд” гэж тус тус өөрчилсүгэй.







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 116

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байхаар тогтоосугай.

3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийг 2024 оны 06 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүд байхаар тогтоосугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 119

Улаанбаатар  
хот

**Монголбанкны Тэргүүн дэд  
Ерөнхийлөгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ганбямбын Дөлгөөнийг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**Индрикс Фолд ога Улсд Норгел ога Доудегелд**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠬᠤ

ᠲᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠬᠤ  
ᠲᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠬᠤ  
ᠲᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠬᠤ  
ᠲᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠬᠤ  
ᠲᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠬᠤ  
ᠲᠤᠭᠠᠰᠤ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Доржсүрэнгийн Занданбатыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**Индрикс Фолд - ога Уагд Норвег ога Доудегд**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠷ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ  
ᠲᠤᠭᠠᠷ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ  
ᠲᠤᠭᠠᠷ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ  
ᠲᠤᠭᠠᠷ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ  
ᠲᠤᠭᠠᠷ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ  
ᠲᠤᠭᠠᠷ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар  
хот

### **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup> дүгээр зүйлийн 16<sup>1</sup>.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүнд цалин хөлс тооцож олгохыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга /Д.Энхбат/-д зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Их Хурлын 2023 оны  
121 дүгээр тогтоолын хавсралт

### **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮНИЙ ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга	5,170,000.00
2	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн	5,070,000.00

---оОо---





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр  
сарын 04-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

### Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын Сүхболд нарыг томилсугай.

2. Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Бямбажавын Ганбат, Жамсранжавын Болд нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



